



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/079/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453317, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,

Утас/факс: 7045-3317,

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2026.02.10 № УВА-2026/079/НА-СТА-ТШБ
танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА А.БОЛОРМАА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас

8525050024

аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16440381.20</u>	<u>104213953.80</u>
33	АВЛАГА	250086.00	25001666.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	250086.00	2232476.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	22769190.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16190295.20	79212287.80
354	Хангамжийн материал	16190295.20	79212287.80
35410	Бичиг хэргийн материал	585500.00	387000.00
35420	Аж ахуйн материал	374000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	15230795.20	78825287.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>688569928.73</u>	<u>741114871.99</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	688569928.73	741114871.99
392	Биет хөрөнгө	643349928.73	695924871.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	502417107.00	502417107.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72168610.61	-84813886.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33600000.00	190600000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25200000.18	-43883333.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	321245941.20	271875543.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-148128733.05	-159982114.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48745412.20	49507175.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24301737.83	-36329118.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	8820340.00	8666500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4390490.00	-4843700.00
39217	Ном	2710700.00	2710700.00
393	Биет бус хөрөнгө	45220000.00	45190000.00
39301	Програм хангамж	150000.00	150000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-30000.00	-60000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	45100000.00	45100000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>705010309.93</u>	<u>845328825.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>23219030.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	23219030.00
413	Өглөг	0.00	23219030.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	2294030.00
4136	Бусад өглөг	0.00	20925000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	20925000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>705010309.93</u>	<u>822109795.79</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	705010309.93	822109795.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	612287721.25	612287721.25
51101	Өмч: - төрийн	612287721.25	612287721.25
512	Хуримтлагдсан үр дүн	-126519665.51	-9420179.65
51210	Өмнөх үеийн үр дүн	-126519665.51	-126519665.51

51220	Тайлант үеийн үр дүн	0.00	117099485.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219242254.19	219242254.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>705010309.93</u>	<u>845328825.79</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8314708143.92	7319189546.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14694786.00	242879456.76
120	Нийтлэг татварын бус орлого	14694786.00	242879456.76
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	14694786.00	174124964.16
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	68754492.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8300013357.92	7076310090.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8160265300.00	6881651600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8160265300.00	6881651600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139748057.92	194658490.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	130452500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41308800.00	14384000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	98439257.92	49821990.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8353029189.30	7183271033.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8353029189.30	7183271033.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1169856884.91	1361391567.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	762932291.73	860213922.00
210101	Үндсэн цалин	426337358.00	515820299.00
210102	Нэмэгдэл	210752993.73	242352560.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86410000.00	67910000.00
210104	Урамшуулал	39431940.00	34131063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93631769.94	106354210.85
210201	Тэтгэврийн даатгал	64844282.69	73449032.97
210202	Тэтгэмжийн даатгал	7604820.75	8583103.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3802410.49	4291052.04
210204	Ажилгүйдлийн даатгал	3466480.85	4006204.82
210205	Эрүүл мэндийн даатгал	13913775.16	16024818.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71072008.86	101929560.51
210301	Гэрэл, цахилгаан	2605093.26	3752733.01
210302	Түлш, халаалт	66307005.60	95511322.50
210303	Цэвэр, бохир ус	2159910.00	2665505.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59887554.00	42569651.00
210401	Бичиг хэрэг	10726400.00	5080500.00
210402	Тээвэр, шатахуун	9004460.00	15765220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695794.00	969431.00

210404	Ном, хэвлэл	30000000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	820000.00	240000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6444600.00	20514500.00
210408	Бараа материал акталсны зардал	2196300.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8647400.00	2000000.00
210604	Урсгал засвар	8647400.00	2000000.00
2107	Томилолт, зочны зардал	41071000.00	37524600.00
210702	Дотоод албан томилолт	41071000.00	37524600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2085520.00	43028830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2120.00	40395100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604800.00	604800.00
210803	Даатгалын үйлчилгээ	143100.00	186030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111500.00	154000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33000.00	33000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740000.00	1250000.00
210807	Газрын төлбөр	451000.00	405900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130529340.38	167770793.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16215500.00	2396800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15456000.00	58993000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98857840.38	106380993.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7183172304.39	5821879465.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	7076998685.50	5796048893.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1650260313.50	1809580893.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5422162372.00	3978168000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4576000.00	8300000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	106173618.89	25830572.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	105869818.89	24718495.49
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	303800.00	1112077.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-38321045.38</u>	<u>135918513.36</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	18819027.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	18819027.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-18819027.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-38321045.38</u>	<u>117099485.86</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>8300013357.92</u>	<u>7076310090.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>8300013357.92</u>	<u>7076310090.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8160265300.00	6881651600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8160265300.00	6881651600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	139748057.92	194658490.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	130452500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41308800.00	14384000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	98439257.92	49821990.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8258273634.92	7072690090.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8258273634.92	7072690090.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1075101330.53	1228041434.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763182377.73	859937050.00
210101	Үндсэн цалин	426337358.00	515543427.00
210102	Нэмэгдэл	211003079.73	242352560.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86410000.00	67910000.00
210104	Урамшуулал	39431940.00	34131063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93631769.94	108613472.85
210201	Тэтгэврийн даатгал	64844282.69	75708294.97
210202	Тэтгэмжийн даатгал	7604820.75	8583103.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3802410.49	4291052.04
210204	Ажилгүйдлийн даатгал	3466480.85	4006204.82
210205	Эрүүл мэндийн даатгал	13913775.16	16024818.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71072008.86	101929560.51
210301	Гэрэл, цахилгаан	2605093.26	3752733.01
210302	Түлш, халаалт	66307005.60	95511322.50
210303	Цэвэр, бохир ус	2159910.00	2665505.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58894754.00	34603621.00
210401	Бичиг хэрэг	12010400.00	4817000.00
210402	Тээвэр, шатахуун	9004460.00	13770290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695794.00	825831.00
210404	Ном, хэвлэл	30000000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	820000.00	240000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6364100.00	14950500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13492400.00	2000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4845000.00	0.00
210604	Урсгал засвар	8647400.00	2000000.00
2107	Томилолт, зочны зардал	41071000.00	18624600.00
210702	Дотоод албан томилолт	41071000.00	18624600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2085520.00	40943330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2120.00	38370100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604800.00	544300.00
210803	Даатгалын үйлчилгээ	143100.00	186030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111500.00	154000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33000.00	33000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740000.00	1250000.00

210807	Газрын төлбөр	451000.00	405900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31671500.00	61389800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16215500.00	2396800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15456000.00	58993000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7183172304.39	5844648655.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	7076998685.50	5796048893.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1650260313.50	1809580893.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5422162372.00	3978168000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4576000.00	8300000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	106173618.89	48599762.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	105869818.89	24718495.49
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	303800.00	23881267.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>41739723.00</u>	<u>3620000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>41739723.00</u>	<u>3620000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>41739723.00</u>	<u>3620000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>41739723.00</u>	<u>3620000.00</u>
221001	Их засвар	36200223.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5539500.00	3620000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-41739723.00</u>	<u>-3620000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	612,287,721.25	219,242,254.19	-88,198,620.13	743,331,355.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,287,721.25	219,242,254.19	-88,198,620.13	743,331,355.31
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-38,321,045.38	-38,321,045.38

2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,287,721.25	219,242,254.19	-126,519,665.51	705,010,309.93
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	612,287,721.25	219,242,254.19	-126,519,665.51	705,010,309.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,287,721.25	219,242,254.19	-126,519,665.51	705,010,309.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	117,099,485.86	117,099,485.86
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,287,721.25	219,242,254.19	-9,420,179.65	822,109,795.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6881651600.00	6856933104.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6881651600.00	6856933104.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1077414500.00	1069184211.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	825416300.00	825416300.00
210101	Үндсэн цалин	479568600.00	515543427.00
210102	Нэмэгдэл	266665300.00	207831810.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41880000.00	67910000.00
210104	Урамшуулал	37302400.00	34131063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104361900.00	104361900.00
210201	Тэтгэврийн даатгал	73152400.00	72774029.31
210202	Тэтгэмжийн даатгал	7805700.00	8237895.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3902800.00	4118447.78
210204	Ажилгүйдлийн даатгал	3900100.00	3846305.61
210205	Эрүүл мэндийн даатгал	15600900.00	15385221.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102557400.00	101929560.51
210301	Гэрэл, цахилгаан	4073200.00	3752733.01
210302	Түлш, халаалт	95905700.00	95511322.50
210303	Цэвэр, бохир ус	2578500.00	2665505.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12023600.00	10543121.00
210401	Бичиг хэрэг	2495300.00	2789100.00
210402	Тээвэр, шатахуун	4166100.00	5378690.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1507700.00	825831.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	717800.00	240000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3136700.00	1309500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22951000.00	22843330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20270100.00	20270100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	544300.00	544300.00
210803	Даатгалын үйлчилгээ	224000.00	186030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161700.00	154000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88700.00	33000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1256300.00	1250000.00
210807	Газрын төлбөр	405900.00	405900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10104300.00	4090000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150000.00	150000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9954300.00	3940000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5804237100.00	5787748893.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5804237100.00	5787748893.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1816670800.00	1809580893.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3987566300.00	3978168000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6881651600.00	6856933104.51
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6881651600.00	6856933104.51
131001	Улсын төсвөөс санхүүжих	6881651600.00	6856933104.51
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	24
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	21	20
620003	Үйлчлэх ажилтан	5	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	170777222.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	170777222.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	162477222.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34520750.00
210102	Нэмэгдэл	34,520,750.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4251572.85
210201	Тэтгэврийн даатгал	2,934,265.66
210202	Тэтгэмжийн даатгал	345,207.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	172,604.26
210204	Ажилгүйдлийн даатгал	159,899.21

210205	Эрүүл мэндийн даатгал	639,596.02
2104	Хангамж, бараа материалын зардал	24060500.00
210401	Бичиг хэрэг	2,027,900.00
210402	Тээвэр, шатахуун	8,391,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,641,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5620000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,620,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	18624600.00
210702	Дотоод албан томилолт	18,624,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18100000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57299800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,246,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,053,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8300000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8300000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	170777222.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170777222.85
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	130,040,422.85
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,684,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,052,800.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд нутгийн удирдлагын оролцоог бодитой болгон бүх шатны боловсролын чанар, үр ашиг, хүртээмжийг дээшлүүлж, сургалтын таатай орчин бүрдүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэхэд оршино.

Боловсролын газар нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

- Багш, удирдах ажилтан, албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх
- Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах
- Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх
- Багш, ажилтны хөгжил, нийгмийн баталгааг хангаж, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар боловсролын салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Хүүхдийн хөгжил, оролцоо, хүүхдийн хамтын үүсгэл санаачилгын идэвхийг дэмжих;
- Зайны сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоон, сургалтын цахим орчныг хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжих;
- “Хүн болох багаасаа” арга хэмжээг өрх гэр, сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд хэрэгжүүлж, зөв хандлагыг төлөвшүүлэх;

- Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орчныг сайжруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол тэгш хамруулж, тусгай хэрэгцээт сургалтын орчныг бүрдүүлэх;
- Монгол, хэл бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх, гудамж талбай, гэр хороолол, үйлдвэрийн бүтээгдэхүүний хаяг, шошгыг монгол бичгээр гаргах;
- Аймгийн боловсролын салбарын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх;
- Боловсрол салбарын мэдээ, мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгох, байгууллагын гадаад, дотоод орчныг сайжруулах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Увс аймгийн Боловсролын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Хөдөлмөр, Нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлс доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,318.5 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	250.1	25,001.7	24,751.6
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	16,190.3	79,212.2	63,021.9
Үндсэн хөрөнгө	688,569.9	741,114.9	52,545.0
Нийт хөрөнгө	705,010.3	845,328.8	140,318.5
Өр төлбөр	0.0	23,219.0	23,219.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	705,010.3	822,109.8	117,099.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	705,010.3	845,328.8	140,318.5

Бараа материалын дансны үлдэгдэл 79,212.2 мянган төгрөг болж 63,021.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар сургууль цэцэрлэгүүдэд хөрөнгө нийлүүлснийг бараа материалын дансанд бүртгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 741,114.9 мянган төгрөг болж 52,545.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр болон Боловсролын яамнаас хөрөнгө шилжиж ирсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 25,001.7 мянган төгрөгийн авлага үүссэн ажиллагчидтай холбоотой авлага буюу НДШ-ийн авлага 2,232.5 мянган төгрөг, Боловсролын үнэлгээний төвөөс ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах 22,769.2 мянган төгрөгийн санхүүжилт 2025 оны 12-р сарын 31-ний өдөр дансанд орж ирээд гүйлгээ хийх эрхийг олгоогүй учраас буцаан татагдсан учир авлага үүссэн байна.

Тайлант онд 23,219.0 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь гүйцэтгэлийн үнэлгээг орон нутагт зохион байгуулсан зохион байгуулагч нарын томилолт, ажлын хөлс, замын зардлын өр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 822,109.8 мянган төгрөг болж 117,099.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,222,741.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 235,638.0 мянган төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийг 6,023,547.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 7,004,650.9 мянган төгрөгөөр анх баталсан байна. Энэ нь сургууль, цэцэрлэгийн багш ажилтны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж болон 5 болон 3 жилд нэг удаа олгох хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг аймгийн Боловсролын газраар дамжуулан олгосноос шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны анх батлагдсан төсвийг 122,999.3 мянган төгрөгөөр бууруулан тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,881,651.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,881,651.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,856,933.1 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 24,718.5 мянган төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71801-Сургуулийн өмнөх боловсрол 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,316,440.0	1,312,340.5	4,099.5	99.7%
2	71802-Ерөнхий боловсрол 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,487,797.1	4,475,408.4	12,388.7	99.7%
3	71808-Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,072,144.4	1,064,158.0	7,986.4	99.2%
4	71808-Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага 80220-Холбооны суваг ашигласны хөлс	5,270.1	5,270.1		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсролын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс 130,452.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 14,384.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 49,821.9 мянган төгрөг, нийт 194,658.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 171,777.2 мянган төгрөгийг зарцуулж, 23,881.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.
Хүснэгт 3. Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжтай холбоотой гарсан зардал	440.0	Хас эрин орчил ХХК-ны динамик санхүүгийн программыг ашигладаг ба жилийн лицензийн төлбөр төлдөг.
2	Унаа хоолны зардлын гүйцэтгэл	67,910.0	Хоолны өдрийн хөнгөлөлтийн зардал 2025 оны 1 сараас 7 сарыг дуустал 15.0 төгрөгөөр тооцож олгож байгаа 2025 оны 9-р сараас эхлэн 10.0 мянган төгрөгөөр тооцож олгосон.
3	Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	72,130.0	БЕГ-ын даргын тушаалаар Архангай, Ховд аймаг болсон сургалтын унааны зардал, багш, удирдах ажилтнуудын үндсэн сургалтын зардал, Аймгийн засаг даргын захирамжаар Дэлхийн иргэн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалт, багш нарын бага хурлын зардлын олгосон.
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал		байхгүй
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	1,024.5	Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхийн анхан шатны шүүхийн 2025.01.07-ны өдрийн 128/ШШ2025/0031
6	Байгууллагын орон тоо	24	Улсын төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагын хүрээнд байгууллагын бүтэц орон тоонд дүн шинжилгээ хийн ачаалал багатай орон тоог цөөлөх, зарим албан тушаалын чиг үүргийг нэгтгэх замаар 3 орон тоог бууруулсан.
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	150.0	Орон нутгийн телевиз болох Сама-Увс ХХК-тай гэрээ 1 жилийн хугацаатай гэрээ байгуулсан боловч 1 улирлын төлбөр болох 150.0 мянган төгрөгийн төлбөр төлж гэрээгээ цуцалсан.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Боловсролын газарт тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Боловсролын газар нь тайлант онд 3,620.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 8,353,029.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 83,530.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 66,824.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,183,271.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 71,832.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 57,466.2 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Боловсролын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Боловсролын газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 164, хугацаа хоцроосон 3, мэдээлээгүй 2, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын газрын нягтлан бодогчид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно” гэж заасныг үндэслэн мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 40 хувиар олгосон байна. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээг тогтоосон эрх зүйн акт байхгүй учраас байгууллага бүрд харилцан адилгүй хувь хэмжээгээр олгож байгааг харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 114,678.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 68,754.5 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 45,933.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

5.1 Албан шаардлага

Увс аймгийн Боловсролын газар нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг зөрчин аймгийн Засаг даргын 2019 оны Б/55 дугаар захирамжаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж, 2022 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Н.Намсрайд 21,477.3 мянган төгрөгийн тэтгэмж, Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг зөрчин боловсролын байгууллагад тасралтгүй 60 болон 36 сар ажилласан байх нөхцөлийг хангаагүй Б.Мөнхбатад 8,400.0 мянга, Ц.Эрдэнэцэцэгт 8,826.0 мянга, С.Минсэлмаад 7,260.0 мянган төгрөгийг тус тус олгосон зөрчилд албан шаардлага өглөө.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан өгсний	1	68,754.5					1	68,754.5				

дараа хөрөнгө нэмж тусгасан.													
Дүн	1	68,754.5					1	68,754.5					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хууль, журам зөрчиж тэтгэмж олгосон	1	45,933.3			1	45,933.3							
Дүн	1	45,933.3			1	45,933.3							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Б.АВИРМЭД/

2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр